

**АЛТАЙ ЯЗГУУРЫН ХЭЛТНҮҮДИЙН ЧОНО ТОТЕМЫН ДОМОГ  
ЖИЧ ШҮТЛЭГИЙН ШИНЖЛЭЛ**

**Г. Намжил** \*

Эртний Алтай язгуурын хэлтэн Монгол, Түрэг үндэстэн угсаатны өвөг дээдсийн өөрөөр хэлбэл тэд нарын овог төрлийн нийгэмд оршиж байсан үед чоныг тотемоо болгон шүтэж байсан мөртөө тус шүтлэгийн нэгэн илрэх хэлбэр болох домог үлгэр ч зохиогдон дэлгэрч байжээ.

“Тотем” гэдэг үг бол Хойд Америк тивийн Алгонкин (*Algonkin*) хэмээгч овог аймгийн нутгийн аялгын үгээс гаралтай. “Тотем” гэдэг үг нь “түүний төрөл садан” гэгдэх утгатай гэдэг.

Тотем шүтлэг бол хүн төрөлхтний нялх балчир үеийн анхны шүтлэгийн нэгэн хэлбэр мөн. Хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн анхны хамгийн онцлог соёлын үзэгдэл болох юм. Овог төрлийн нийгмийн шат үед оршиж амьдарсан овог ястан буюу хувь хүн ямар нэгэн араатан жигүүртэн зэрэг амьтай бодос буюу чулуу мод, тэнгэр, одод зэрэг амьгүй бодосыг өөрийнхөө өвөг дээдэс үүсэл гарлаа гэж үзэж, шүтэн биширдэг байжээ.

Тэдгээр амьтай буюу амьгүй бодос бол овог яс буюу хувь хүний тотем мөн. Тотемоо шидчилэн зохиосон домгуудыг тотемын домог гэнэ.

Монгол, түрэг хэлтнүүдийн тотем шүтлэг бол алс эртний шүтлэгийн хэлбэр болохоор түүний дотоодын нарийн зүйлүүд нь нэгэнт балран мартагдаж зөвхөн бичиг дурсгал буюу амаар дамжин уламжлагдаж ирсэн цөөхөн хэдэн домог үлгэрүүд нь манай эрин хүртэл үлдсэн байна.

Иймээс бид зөвхөн цөөхөн хэдэн чоно тотемын домгоор монгол, түрэг хэлтнүүдийн чоно тотемын шүтлэгийг магадлан илрүүлэх боломж бий.

**Нэг. Өлөгчин чоно тотем домог жич шүтлэг**

Эртний Алтай язгуурын Монгол, Түрэг хэлтнүүдийн өвөг дээдсийн үед өлөгчин чоныг овог ястныгаа үүсгэгч өвөг дээдэс болгон тотемлож байжээ. Эдгээр шүтлэг нь бичиг дурсгал дахь тэмдэглэл буюу амаар дамжин дэлгэрсэн тотемын домогт илэрч байдаг.

---

\* БНХАУ-ын Төвийн Үндэстний Их Сургуулийн профессор

Монгол, түрэг хэлтнүүдийн дотор дэлгэрсэн өлөгчин чоно тотемийн домог нь голдуу дайн дажны аюулаас амьд үлдсэн эрэгтэй нялх хүүхэд буюу хүүхдийг өлөгчин чоно авран тэтгэж, сүүлд тус эрэгтэйтэйгээ нийлж үр хүүхэд гаргаж, шинэ овог аймгийг үүсгэсэн гэж өгүүлдэг. Ийм домгийн хамгийн түрүүнд “Түрэгийн Ашина овогтны чоно тотем”-ын домгоор жишээлж болно. Хятадын эртний түүхийн сурвалж бичиг “Жөү шу бичиг”-ийн “Түрэгийн намтар”-т тэмдэглэсэн нь:

*“Түрэг” хэмээгч болбоос Хүннүгийн нэгэн овог аймаг бөлгөө. Ашина хэмээх овогтон сүүлд нэгэн удаа зэргэлдээ улсдаа ялагдаж овог угсаагаараа бүр хядагдав. Арван настай нэгэн хүү амьд үлдэв. Цэргийн ард энэ хүүхдийн нас бага хэмээн өрөвдөж, алж ядаад хөлийг нь огтолж, гарын тасдаад өвстэй намагт хаяжээ. Тэндээс нэгэн өлөгчин чоно ирж энэ хүүхдэд мах өгч тэжээв.*

*Энэ хүүхэд том болоод тэр өлөгчин чонотой ураглан амьдарч, өлөгчин чоно жирэмсэн болов.*

*Нөгөө улсын хаан нь тэр хүүг амьд байгааг мэдээд хүн илгээж алуулжээ. Тэр ирсэн хүн өлөгчин чоно мөн тэнд байхыг үзээд чоныг мөн алсу хэмээв. Чоно дутааж Гоу чан хэмээгч уулсын ар ууланд хүрч нуугджээ. Тэр ууланд нэгэн агуй бий. Агуйн дотор тэгш сайхан талтай. Тал дүүрэн өвс ногоо ургажээ. Энэ тал газар эргэн тойрон хэдэн зуун газар өргөн уудам, дөрвөн талаараа уул нуруудаар хүрээлэгджээ. Өлөгчин чоно тэр агуйн дотор нуугдаж, арван хүү төрүүлжээ.*

*Арван хүүхэд нь том болоод тус бүр бусад овог аймгаас нөхөр гэргий буулгаж тус, тус нэгэн овог аймаг болсон ажгуу. Энэ арван овогтон нар энэ агуй дотор хэдэн үе амьдарч, хамтаар зөвлөж уулан дахь агуйгаас гарч Рү рү хэмээх улсад дагавай.*

*Тус арван овогтон Алтай уулын хормойд нутаглав. Рү рү улсын төмөрчин болжээ. Алтай ууланд оргил нь дуулга хэлбэртэй болохоор эдгээр арван овогтод өөрсдийгөө Түрэг хэмээн нэрлэжсүхүй.*

*Тэдний ярианд дуулгыг түрэг хэмээн нэрлэдэг ажгуу<sup>1</sup>.*

Түрэгчүүд бол манай эриний VI-VII зууны үед Монголын өндөрлөгийн ар тал Алтай, Хангай уулны өргөн уудам нутагт нүүдэллэн малжсан үндэстэн угсаатан болсон. Түрэгчүүд бол яриангүй түрэг төрөлх хэлтэн. Тэд нар мөн бусад түрэг хэлтнүүдтэй адилаар чоныг шүтэж тотемлодог байжээ.

Дээрхи домгоос ажиглавал, эртний Түрэгчүүд өлөгчин чоныг тотемлож шүтэж, овгийн үүсгэгч өвөг дээдэс гэж үзэж байжээ. Тус домогт тотемын амьтан хүнтэй нийлж, үр хүүхэд гаргаж, шинэ овог ясыг үүсгэсэн гэдэг тотем шүтлэгийн үндсэн сэтгэлгээг илтгэжээ.

Дундад Азийн өргөн уудам нутаг дэвсгэр дээр тархан амьдарсан Түрэг хэлтэн Казакчууд бол мөн чонын шүтлэгтэн юм. Казакын зарим овог аймаг бас өөрсдийгөө өлөгчин чоноос гаралтай гэж үздэг байжээ. Жишээлбэл: Казакын Найман хэмээгч овог аймаг нь өлөгчин чоныг эмэгтэй үүсгэгч дээдэс хэмээн үздэг юм. Найманчуудын дунд өлөгчин чоно тотемын домог зохиогдон дэлгэрчээ. Тус домгийг бас “Эргүнэ хун

<sup>1</sup> 【唐】令狐德棻等著【周书】卷五十《突厥传》，中华书局，1971年版，第510页。

Найманчуудын домог” гэж эхэлдэг. Энэ домогт хэлсэн нь:

*Эрт урьдын цагт Алтай уулын энгэрт нутаглаж байсан Найман хэмээгч овог ястан зэргэлдээ аймгийн гэнэтийн дайралтад учрав. Тэр аймгийнхан Найманчуудыг хядан алж, булаан дээрэмдэж дуусгав. Дайсан этгээд нэгэн хөгшин баатар эрийн дөрвөн мөчийг таслаж, үхлүүд үлдээв. Энэ үед нэгэн өлөгчин чоно баатрын дэргэд хүрч ирээд шархыг нь долоосонд шарх нь удсангүй эдгэрэв. Өлөгчин чоно баатрыг дагуулан Алтай уулын нэгэн асаг хадны доорхи агуйд аваачиж, эр эм бололцон амьдрал. Сүүлд баатар хийгээд өлөгчин чоноос үр хүүхэд төрж, үржээд энэ Найман хэмээх овог аймаг дахин үүсч, хөгжив. Өлөгчин чоно хийгээд хөгшин баатрын бие далдлан амьдарсан тэр агуйг нь Алтай уулын Эргүнэ хун гэдэг уулын оргилд байдаг болохоор эдгээр Найманчуудыг “Эргүнэ хун Найманчууд” гэж нэрлэх болжээ<sup>2</sup>.*

Дээрхи Казакийн Найманчуудын домог нь Түрэгчүүдийн домогтой адил дайны хөлөөс амьд үлдсэн хүнийг өлөгчин чоно аварснаар барахгүй, тэр хүнтэй эр эм бололцон үр хүүхэд төрүүлж, шинэ овог аймгийг үүсгэсэн үлгэрийг өгүүлжээ.

Дээрхи үлгэрүүдэд овог төрлийн нийгэм дэхь овог аймгаа ямар нэгэн амьтан буюу ургамал эсвэл ямар нэгэн амьгүй бодсоос ирэлтэй гэх тотем шүтлэгийн үзэл ойлголтыг үзүүлэн харуулжээ. Эдгээр домгуудаас эртний түрэг хэлтнүүдэд өлөгчин чоно тотемын шүтлэг дэлгэрч байсан гэдгийг ойлгож болно.

### **Хоёр. Эрэгчин чоно тотемын шүтлэг жич домог**

Эрэгчин амьтан араатан эмэгтэй хүнтэй ураглаж, үр хүүхэдтэй болж, шинэ овог аймаг үүсгэсэн гэх тотемын домог бол дэлхийн олон үндэстны дотор өргөн дэлгэрсэн байдаг.

Монгол, Түрэг зэрэг алтай хэлтнүүдэд иймэрхүү хэвшлийн домог зохиогдон дэлгэрч, тэдний эрэгчин чоно тотемын шүтлэгийг харуулж байдаг. Хамаг түрүүнд Гао чэ хэмээгчийн Түрэг хэлтэн үндэстний дотор дээр ярьсан эрэгчин чоно тотемын домог дэлгэрч байдаг. Энэ домгийг мөн Хятадын эртний түүхэн сурвалж бичигт “*Вэй ши бичиг*”-ийн “*Гао чэ-чүүдийн намтар*”-т тэмдэглэгдэн үлдээжээ. Тэр домгийг бид “*Гао чэ-чүүдийн чоно тотемын домог*” хэмээн нэрлэе. Тэр домогт өгүүлсэн нь:

Ардууд ийм нэгэн үлгэрийг ярьдаг бөлгөө. *Хүннү улсын Чань Юү хаан хоёр охинтой байжээ. Тэр хоёр охин нь маш үзэсгэлэнтэй. Тэр улсын ард иргэд нь тэр хоёр охиныг хувилгаан сахиулсан гэж үздэг байжээ. Нэгэн удаа Чань Юү хаан хэлсэн нь: -Миний энэ хоёр охиныг энгийн хүнд хэрхэн ураглаж болох аж. Тэнгэрт өргөсүгэй гэжээ. Тэгээд улсын умард хэсэг дэх нэгэн хүний хөл хүрээгүй газарт өндөр тайз байгуулж хоёр охиноо тайзан дээр суулгаж, энэ хоёр охиныг “тэнгэр ирж авч яваарай” гэжээ. Хоёр охин тэр тайзан дээр гурван жил сууж, хэн ч авч явсангүй. Чань Юү хааны хатан хоёр охиноо буцаан авч ирсүгэй гэхэд Чань Юү хаан хэлсэн нь: -Тэгж үл болно. Цаг нь хараахан болоогүй байна гэж үл зөвшөөржсүхүй. Энэ мэтчилэн бас нэгэн жил өнгөрсөн хойно нэгэн хөгшин эр чоно тайзан доор ирж, тайзны доогуур нүх малтан удтал сууж,*

<sup>2)</sup> 再努力, 桑尼克《哈萨克动物故事》载《遗产》(哈萨克文)杂志1985(314)

салж явахгүй болсон байна. Чань Юу хааны бага охин нь чоныг үзээд хэлсэн нь: -Эцэг маань бид хоёрыг энэ тайзанд суулгасан нь тэнгэрт өргөх гэсэн бөлгөө. Одоо энэ хөгшин чоно ирсэн нь тэнгэр явуулсан байж мэднэ гэж тайзнаас бууж чонод очсугай гэжээ. Гэтэл эгч нь их цочин гайхаж өгүүлэв.

-Энэ бол араатан амьтан болой. Эцэг эхийн нүүрийг битгий барахтун гэсэнд дүү нь эгчийнхээ үгийг үл тоомсорлон тайзнаас бууж, чонотой гэрлэн үр хүүхэдтэй болжээ. Үр хүүхэд нь хожим нэн үржин олироод нэгэн улс гүрэн болсон бөлгөө. Ийм учраас тэдний дуу дуулах нь чоно улихтай адил ажгуу<sup>3</sup>.

Гао чэ хэмээгчийн Түрэг хэлтнүүд бол манай эриний V зууны үед Монголын өндөрлөгийн ар талаар нутаглаж байжээ. V зууны сүүл үеэр Алтай уулын баруун бэлд нүүдэлчдийн эзэнт гүрнийг байгуулжээ.

Гао чэ-чүүд бол үнэндээ эртний Уйгарын нэгэн салаа үндэстэн болно. Тэдний нэрийдэл “Гао чэ” гэдэг бол Хятад хэлний “Өндөр хүртэд тэрэг” хэмээх утгатай. Бичиг дурсгалын тэмдэглэлийг үзвэл Гао чэ-чүүд нүүдэлчин хүмүүс байж нүүдлийн амьдралдаа ер өндөр хүртэд тэрэг хэрэглэдэг болохоор хятад түүхчид Уйгараас ялгаж салгахын тулд тус нэрийдлийг хэрэглэжээ. Иймээс Гао чэ гэдэг бол Уйгараас салбарлаж гарсан нэгэн үндэстэн үгсаатан болох нь тодорхой юм.

Уйгарчууд бол мөн Түрэг хэлтэн бөгөөд бусад Түрэг хэлтнүүдтэй адилаар чоныг тотемлон шүтдэг байжээ. Гэхдээ олонх Түрэг хэлтэд өлөгчин чоныг тотем болгон шүтдэг бол Гао чэ-чүүд харин эрэгчин чоныг шүтэж эрэгчин чоноор овог аймгийнхаа тотемоо болгодог байжээ. Эртний овог аймгийн эрэгчин чоныг шүтэх буюу өлөгчин чоныг шүтэх нь зөвхөн өнгөн талын асуудал биш. Харин хүн төрөлхтний овог төрлийн нийгмийн хөгжлийн алхацтай харгалзан тотем шүтлэгийн хувирал улирлын шат үеийн онцлогийг тусган харуулж байгаа юм. Тус домог нь бас Гао чэ-чүүд бол Хүннү улсын Чань Юу хааны охин хийгээд эрэгчин хөгшин чонын хойчис мөн гэдэг тотем шүтлэгийн ойлголт сэтгэлгээг тусган харуулсан байдаг.

Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд эхээ мэддэг, эцгээ мэддэггүй цаг үе байж өнгөрөв. Тэр үеийн хүмүүс овог аймаг буюу хувь хүнээ тотемоос гаралтай гэж үздэг болохоор мэддэггүй эцгээ тотемоороо заан нэрлэсэн байж болох юм.

Тэдний үзэхээр овгийн эмэгтэй дээдэс, эрэгчин чонотой ураглаж, шинэ овог аймгийг бий болгожээ. Дээрх домог нь бидэнд бас Гао чэ-чүүд эрэгтэй чоныг шүтэж тотемлодог гэдэг мэдээ зангийг мэдэж болж байна. Үүнийг цаашид нягтлан бодвол, эртний Алтай язгуурын хэлтнүүдэд эрэгчин чоно тотемын шүтлэг оршиж байсан аж. Тухайлбал Монголчуудын өвөг дээдсийн үед мөн эрэгчин чоныг тотем шүтээнээ болгож байсан байж магад. “Монголын Нууц Товчоон”-д тэмдэглэсэн нь:

*Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу, гэргий ину Хоа марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ “Бурхан Халдун” уулнаа нутаглаж төрсөн Батаач хан ажгуу.*

Яриангүй Бөртэ чоныг түүхэн хүн үү?, тотем амьтан юм уу? гэдэг асуудалд

<sup>3)</sup> 【北齐】魏收著《魏书》卷一〇三《高四传》，中华书局，1972年版，第2307页。

эрдэмтдийн санал үзэл адил биш, одоо ч маргалддаг.

Бид хэрэв *Бөртэ* чоныг Монголчуудын шүтдэг эрэгчин чоно тотем мөн гэвэл Бөртэ чоно, Хоа маралын домог нь мөн Гао чэ-чүүдийн домогтой адил талтай байдаг.

Өөрөөр хэлбэл, Бөртэ чоно бол Монголчуудын өвөг дээдсийн үе дээр шүтдэг эрэгчин амьтан тотем байжээ. Хоа марал бол хүн төрөлхтний эртний овог аймгийн эмэгтэй дээдэс мөн. Тэр Бөртэ чоно хэмээх эрэгчин чоно тотемтой нийлж Батаач хан хэмээн хүүг төрүүлжээ. Батаач ханаас үр хүүхэд үржиж Монгол хэмээх овог аймгийн буй болох суурийг тавьсан байна.

Алтай язгуур хэлтэн үндэстний эртний эрэгчин чоно буюу Бөртэ чонын тотем шүтлэгийн ул мөрийг дээрх Гао-чэчүүд ба Монголчуудын домгоор нотолж болох юм.

Гэвч гэрч баримт болмоор домог жич бусад материалууд нь маш хомс байна. Үүнээс цаашид шинэ шинэ материалыг ирж гаргаж, гүнзгий дүгнэлтэд хүргэх чухалтай болж байна.

#### **Гурав. Чоно тотем овгийн үүсгэгчийг авран тэтгэсэн домог**

Алтай хэлтэн Монгол, Түрэг үндэстнүүдэд чоно тотем амьтан шинэ овгийн үүсгэгчийг нялх балчир байхад нь авран тэтгэж тэжээн өсгөсөн гэх домог зохиогдон дэлгэрч байжээ. Ийм домог буюу домгийн хувилбар нь эртний Ү Сүн, Хүннү, Киргиз үндэстэн ба Монголчуудын дотор дэлгэрч байжээ.

Хамаг түрүүнд тус домог нь эртний Ү Сүн хэмээх Түрэг хэлтэн үндэстэн ба Хүннүчүүдийн дотор дэлгэрч байжээ. Тус домгийг эртний Хятадын түүхч Сы Ма Чэнь-ий туурвисан “Түүхэн тэмдэглэл” гэдэг сурвалж бичиг ба мөн Хятадын эртний түүхч Бан Гү-гийн туурвисан “Хан шү бичиг”-т тэмдэглэж буй. Энэхүү домгийг бид эртний Ү Сүн үндэстний чоно тотемын домог хэмээн нэрлэе.

*Ү Сүн хэмээгч улсын бага хааны цол нь Күнмө гэдэг. Күнмөгийн эцэг нь улс юүгээн ноёрхон Хүннү улсын баруун талд нутаглаж байжээ. Хүннү улс Ү Сүн улс дайлан Күнмөгийн эцгийг нь алж саяхан төрсөн нялх Күнмөг хээр хаяв. Энэ үед нэгэн хар хэрээ нисэн ирж нялх хүүхдийн аманд мах үмхүүлж тэжээв. Мөн нэгэн өлөгчин чоно ирж хүүхдийг хөхүүлэн тэжээж амьдруулав. Хүннүгийн Чань Юү хаан үүнийг үзээд машид цочин гайхаж энэ хүүхэд бол хувилгаанаас явуулсан болой гэж гэртээ авч ирэн тэжээн өсгөв.*

*Энэ Күнмө хэмээгчийн хүүхэд том болоод цэрэг дайчлан Хүннү улсад хэдэн удаа гавьяа байгуулав. Хүннүгийн Чань Юү хаан нь түүнд итгэж эцгийнх нь ард иргэдийг тушаан өгч, баруун хязгаар орныг захируулжихуй. Күнмө ард иргэдээ хураан цуглуулж эргэн тойрны бага, бага улс иргэдийг орлон авч хэдэн түмэн цэрэг ардын эзэмшин захирав. Чань Юү хаан үхсэнд Күнмө ард иргэдээ дагуулан нүүж өөр нэгэн улс байгуулж Хүннү улсыг дагахгүй болжээ. Хүннү улс гавшгай цэрэг илгээж дайлгасан боловч ялж чадсангүй. Хүннү улсын цэрэг Күнмөг хувилгаанаас явуулсан гэдэгт итгэж хол зайлан явбай<sup>4</sup>.*

<sup>4</sup> 【汉】司马迁著《史记》卷一二三《大宛列传》，中华书局，1972年版，第3168页。

Эртний Ү Сүн хэмээгч үндэстэн угсаатан бол манай эриний өмнөх III зууны үед одоогийн Хятад улсын баруун хойд хэсэг дэх Гансү хэмээх газарт нутаглаж байгаад сүүлд одоогийн Хятад улсын Шинжааны баруун хэсэгт нүүдэллэн явав.

Тус домгийг Хятадын Хан улсын элчин сайд Жан Чань \?- МЭӨ 114 он\ хэмээгч бээр Хүннү улсад баригдаад байсан үедээ Ү Сүн-ий домгийг Хүннүчүүдээс сонсон тэмдэглэж авсан байжээ. Иймээс дээрхийг хэдийгээр Ү Сүн-ий тухай домог байсан ч мөн Хүннүчүүдийн дунд дэлгэрч байжээ.

Тус домог нь Ү Сүнчүүд бас хэрээ болон чоныг шүтэж эдгээр араатан амьтнаар тотемлодог гэх мэдээ зангийг дамжуулж байна.

Эртний Ү Сүн хийгээд Хүннүчүүдийн хэл яриа, зан дадгал адил, угсаа гарал нэгтэй үндэстэн тул Хүннүчүүдийн дотор ч чоно тотем шүтлэг дэлгэрч байсан байж магад.

Киргизчүүд бол мөн Түрэг хэлтэн үндэстэн. Тэд мөн чоныг тотемлон шүтдэг байжээ. Киргиз ардын дунд дэлгэрсэн “Өндөр дэлт” гэдэг домогт өгүүлсэн нь:

*Эрт урьдын цагт нэгэн алхаж явж чаддаггүй, зэрэмдэг эрэгтэй хүүхэд байсан гэнэ. Аав ээж нь түүнийг зэрэмдэг хэмээн голж аглаг ууланд аваачиж хаясан байжээ. Гэтэл энэ үед нэгэн өлөгчин чоно ирж өнөөх хүүд сүүгээ хөхүүлж, тэжээн өсгөв. Сүүлд хүмүүс тэр хүүхдийг олж аваад гэртээ аваачиж тэжээн өсгөв. Тэр хүүхдэд Каба гэдэг нэр өгчээ. “Каба” гэдэг үг бол Киргиз хэлэнд “Өндөр дэлт” гэсэн утгатай. Учир нь тэр хүүгийн үс гээг нь чонын дэлтэй адил урт байжээ. Хүмүүс түүнийг Өндөр дэлт хэмээн нэрлэсэн нь ийм учиртай. Хожим нь Өндөр дэлтийн үр хүүхэд нь нэгэн овог болж үржиж “Өндөр дэлт овог” хэмээн алдаршив. Энэ үеэс эхлэн Киргизчүүдийн дотор Каба гэдэг овог аймаг буй болжээ.*

Эртний Ү Сүн хийгээд Киргизчүүдийн домогт хаягласан хүүхдийг өлөгчин чоно ирж авран тэтгэж тэжээн өсгөдөг. Чонод тэжээгдсэн эр хүүхэд өсөж том болоод шинэ овог аймаг үүсгэх буюу шинэ улс гүрэн байгуулан аугаа их үйлсийг бүтээдэг.

Эдгээр домгуудад хэдийгээр Түрэгчүүд, Найманчуудын домог шиг чонод тэжээгдсэн тэр хүүхэд хожим нь өлөгчин чонотой ураглан үр хүүхэд гаргах мэтийн домгийн мотив өгүүлэмж гардаггүй боловч домогт гардаг өлөгчин чоно шинэ овог аймгийн үүсгэгчийг авран тэтгэж, тэжээн өсгөж хожим шинэ овгийн үүсэлд маш чухал үйлдэл үзүүлсэн гэх мэтийн мотив өгүүлэмж гардаг.

Иймээс эдгээр домог нь мөн эртний Ү Сүн ба Киргиз бол чоно шүтлэгтэн, өлөгчин чоноор тотем шүтээн болгодог гэх тотем шүтлэгийн үндсэн сэтгэлгээг гаргаж байна. Иймээс домог дахь өлөгчин чоно бол эртний Алтай язгуурын хэлтэн Ү Сүнчүүд хийгээд Киргизчүүдийн тотем шүтээн мөн.

Эртний Монголчуудын доторч чоно тотем шинэ овгийн үүсгэгчийг авран тэтгэж тэжээн өсгөсөн домог байсан юм. Гэтэл тэдгээр домог нь нэгэнт мартагдсан бололтой. Зөвхөн тэдгээрийн үлдвэр буюу домгийн хэсэг мотив өгүүлэмж зарим нэгэн домог ярианд шингэж бидний эрин хүртэл уламжлагдсан байна. Халх Монголчуудын дунд дээрх домгийн мотив өгүүлэмжийг баттай түүхэн хүнтэй холбосон домог яриа болж дэлгэрсэн байна. Тэр домог ярианд өгүүлсэн нь:

19-р зууны сүүлч үед Монголын Хонгор аймгийн *Баянговь сумын нэгэн ядуу охин*

*баян айлд зарцлагдаж байгаад жирэмслэв. Баян айлынхан гэрт нь охин төрвөл айл гэрийг бузарлана гэж охиныг гэрээсээ хөөж гаргав. Охин нэгэн уулын агуйд хүрч нярайлав. Тэр хүүхдээ агуйд үлдээн өөрөө идээ олохоор гадагш гарав. Тэр өдөр салхи шуургатай, хүүхний бие нь ч тэнхэрч чадаагүй тул манаран ойчжээ. Энэ үед нэгэн малчин алдсан малаа эрж явах замд хүүхнийг олж хүүхнийг гэртээ авч ирж халуун цай уулгаж тамир тэнхээ оруулан эдгээж авав.*

*Хүүхэн сэргээд хээр хүүхдээ төрүүлснээ хэлсэнд айлын олон хүмүүс хүүхэнтэй хамтаар хүүхдийг эрэхээр уулын агуйн амсарт хүрч очиход агуйгаас нэг хэрээ нисэн гарч хойноос нь нэгэн өлөгчин чоно гүйн гарахыг олж харжээ.*

*Тэдгээр хүмүүс хэрээ хүүхдийн нүдийг малтаж, чоно хүүхдийг идчихсэн байгаа гэж боджээ. Гэтэл агуйд ороод үзэхэд нялх хүүхэд харин амьд сэрүүн, амгалан тайван байв. Тэр хүүхэд яг сайхан хөхөө хөхсөн шиг гэдэс цатгалан байв. Уруул дээр нь бас сүү наалдсан эргэн тойрноо сонирхолтой харж байсан гэдэг.*

*Энэхүү чоно хэрээнд тэжээгдэж өссөн хүүхэд сүүлд алдар нэр мандсан дээд лам Жамбалзундуй байжээ<sup>5</sup>.*

Дээрх домог ярианд хаягдсан хүүхдийг чоно /хэрээ/ авран тэжээсэн гэх мэт тотемын домгийн мотив өгүүлэмж гардаг. Эдгээр домгийн мотив өгүүлэмж нь эртний Ү Сүн, Түрэг ба Киргизийн домог бүрт гардаг байна. Монгол домог ярианд тэжээгдсэн хүүхэд чонотой ураглаж, үр хүүхэд төрүүлж шинэ овог аймгийг үүсгэх гэх мэтийн домгийн мотив өгүүлэмж гарахгүй боловч харин тэр чоно /хэрээ/-д тэжээгдсэн хүүхэд хожим нь ар, өвөр Монголд алдар нэр нь мандсан дээд лам, хуврага болсон гэх мотив өгүүлэмж гардаг юм.

Ер нь дээд лам, хуврага нялх үедээ чонод хөхлөгдөн өссөн гэх домог яриа Өвөрмонголын Алшаа Монголчуудын дотор ч дэлгэрч байжээ.

Алтай язгуур хэлтэн үндэстнүүдийн чоно тотемын домгууд дахь чонод тэжээгдсэн хүүхэд том болоод шинэ овог аймгийн үүсгэгч буюу улс гүрэн байгуулагчаасаа өндөр дээд лам, хуврага болж хувирсан явц нь яг сайхан нийгэм түүх ба хүмүүсийн үзэл ойлголтын хувиралтын шат үедээ алхаа нэгдэж байгааг харуулж байна .

Дээрх домог ярианд эртний Түрэг хэлтэн үндэстнүүдийн чоно тотемын домгийн мотив өгүүлэмж гарч байгаа явдал нь эртний Монголчуудын өвөг дээдсийн үед буюу овог төрлийн нийгмийн үед өлөгчин чоноор тотемлогдох тотем шүтлэг дэлгэрч байсан гэдэг дүгнэлтийг гаргаж болно. Тэрчлэн дээрх домгууд нь Алтай язгуурын Монгол, Түрэг хэлтэн үндэстнүүдийн дээдсийн үе дэх чоно тотемын шүтлэгийн нэгдэлтэй байгааг гэрчлэн нотолж байна.

Дээрхийг хураангуйлан дүгнэвэл:

Алтай язгуурын Монгол, Түрэг хэлтнүүдийн өвөг дээдсийн үед өлөгчин чоно тотемын домог, эрэгчин чоно тотемын домог ба чоно тотем амьтан овгийн үүсгэгчийг

---

<sup>5</sup>) Г.Аким зохион Хурц буулгасан “Тэнгэрийн нохой”, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2000; 2002, 92-93-р тал.

авран тэтгэсэн домог зохиогдон дэлгэрч байжээ.

Эдгээр домгууд нь эртний Алтай язгуур хэлтнүүдийн овог төрлийн нийгмийн үеийн чоно тотемын шүтлэгийг ямар нэгэн хэмжээгээр харуулан тусгаж байгаа аж.

## НОМ ЗҮЙ

1. «Тан улс» Лин Гэү Хө Бэнь зохиов. «Жөү шү бичиг», Ү боть, «Түрэгийн намтар» Жүнхуа бичгийн хороо, 1971, 510-р хуудас
2. «Өв хөрөнгө» казак хэлний сэтгүүл, 1985, 3-4-р хугацаа
3. «Хойд Чи улс» Вэй шү зохиов. «Вэй шү бичиг»-ийн 103-р боть, «Гао чэ-чүүдийн намтар» Жүнхуа бичгийн хороо, 1972, 2307-р хуудас
4. «Хан улс» Сы Ма Цянь зохиов. «Түүхэн тэмдэглэл» 124-р боть, «Да вань-ий шаштир» Жүнхуа бичгийн хороо, 1972.

## SUMMARY

Totem myths related to wolf and she-wolf were created during the time of ancestors of the Mongolians and Turks whose languages are included in the Altaic language family. These myths reflect the worship of wolf totem in the tribal society of ancient Altaic language family.